



ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Д.БАЯРБАТ ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-2460.
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2024. 04. 16 № 01/3055
танай _____-ны № _____-т

Авлигын эсрэг арга хэмжээг
эрчимжүүлэх тухай

Авлигатай тэмцэх газрын Ажлын хэсэг 2014 оны 2 дугаар сарын 10-наас 15-ны өдрүүдэд Төв аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагууд болон Зуунмод, Сэргэлэн, Лүн, Заамар, Жаргалант, Цээл, Борнуур, Баянчандмань сумдын хүрээнд авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалтай танилцлаа.

Ажлын хэсэг ажиллах хугацаандаа аймаг, сумдын иргэд олон нийттэй уулзан санал хүсэлтийг нь сонсож, тэдгээрийн гомдол мэдээллийн мөрөөр ажиллахын зэрэгцээ иргэдэд болон нийтийн албан тушаалтанд авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан таниулж, авлигын эсрэг үйл ажиллагааг хариуцдаг эрх бүхий албан тушаалтнуудад төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангахад чиглэсэн мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлсэн.

Аймгийн хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд сургалт сурталчилгаа явуулах, ХАСХОМ /хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг/-ийг бүртгэж, мэдээ тайлан гаргах, хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлыг хэвшүүлсэн байх бөгөөд байгууллага авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн үйл ажиллагаа нэн хангалтгүй гэж дүгнэлээ.

Нэг. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх нийтлэг үүргийн хэрэгжилт:

1/ Байгууллагын түвшинд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг шинээр тогтоон мөрдүүлэхтэй холбоотой арга хэмжээ огт авч хэрэгжүүлээгүй;

2/ нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэгт Авлигатай тэмцэх газраас дүгнэлт гаргуулах, ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдэл гаргах, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй албан тушаалтанд урьдчилан сэргийлэх зөвлөмж хүргүүлэх, давхар ажил эрхлэх

005809

боломжтой эсэхийг шийдвэрлэх зэргийг хэрэгжүүлдэггүй бөгөөд энэ талаарх бүртгэл хөтлөлтгүй;

3/ албан тушаалтанд тавигдах хориглолт хязгаарлалтыг зөрчиж хандив зохион байгуулах, хандивлагчтай холбоотой шийдвэр гаргах, бэлэг санхүүгийн туслалцаа авах явдал нийтлэг хавтгайрсан;

4/ нутгийн захиргааны байгууллагаас аж ахуйн нэгж, компанид дарамт, шахалт үзүүлсэн гэрээ байгуулах, хуулиар хориглосон зохимжгүй нөлөөлөл үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалттай компанид давуу байдал олгосон зэрэг авлигын зөрчил ихтэй /Нийгмийн хариуцлагын гэрээ/ ;

5/ ашиг сонирхлын зөрчилтэй болон ашиг сонирхлын зөрчилтэй гэж ойлгогдохуйц нөхцөл байдалтай шийдвэрүүд гаргах, төсвийн болон хандивын хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зэрэг зөрчлүүд түгээмэл байна.

Хоёр. Сум хөгжүүлэх сангийн талаар:

Ажлын хэсэг Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийн байдалтай танилцахад:

- төслийн талаарх мэдээлэл ил тод бус;
- сумдын удирдлагууд өөрийн хамаарал бүхий этгээдэд зээл олгох явдал нийтлэг байх бөгөөд ийнхүү шийдвэрлэхдээ ашиг сонирхлын зөрчлийн мэдэгдлийг гаргадаггүй;
- сан нь Төрийн санд тусгай данстай байх шаардлагыг хангаагүй;
- зээлийн мөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг;
- ИТХ-аас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоогоогүй зэрэг болно.

Гурав.ХАСХОМ-ийн шалгалтын талаар:

Төв аймгийн болон сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх агентлагуудад хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ бүртгүүлдэг нийт 1200 албан тушаалтны мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтыг хийхэд, давхардсан тоогоор нийт 1604 зөрчил илэрснээс 1053-ыг буюу 65,6 хувийг нь ИТХ-ын ажлын албанд, 551-ийг буюу 34,3 хувийг ЗДТГ-т мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын зөрчил тус тус эзэлж байна.Үүнд:

1/ Мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар илэрсэн нийт зөрчлийн 358 нь хувийн ашиг сонирхлын мэдүүлгийн “хамаарал бүхий этгээдэд” хэсгийг мэдүүлээгүй, 318 нь хөрөнгө, орлогын эх үүсвэрийг хангалтгүй тайлбарласан;

2/ 424 нь мэдүүлгийг гарын үсэг зурж баталгаажуулаагүй, 189 нь орлогоо сараар мэдүүлсэн, 144 нь хөрөнгийн эх үүсвэрийг тайлбарлаагүй, 117 нь компани, үүсгэн байгуулсан хуулийн этгээдийн талаар мэдүүлээгүй, 53 нь мэдүүлгээ бүрэн гүйцэд гаргаагүй;

3/ Төв аймгийн ИТХ-ын ажлын алба, сумдын ИТХ-ын ажлын албанд мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын мэдүүлгийн маягтыг бөглөсөн байдал нь хууль, тогтоомжид заасны дагуу хангалттай түвшинд хийгдээгүй;

4/ аймаг, сумдын Засаг даргын Тамгын газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын мэдүүлгийн маягтыг бөглөсөн байдал хууль, тогтоомжид заасны дагуу хийгдсэн боловч зарим сумдад харилцан адилгүй байна. Тухайлбал, Баян-Өнжүүл, Баянчандмань, Угтаалцайдам, Зуун мод сумын ЗДТГ-ын албан тушаалтнууд мэдүүлгийн маягтыг бөглөсөн байдал бусад сумдын албан тушаалтнуудынхаас сайн;

5/ 2012 оны сонгуулиар шинээр сонгогдсон аймаг, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн дийлэнх нь Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомж, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргах заавар, зөвлөмжтэй танилцаагүй, эсхүл энэ талын мэдээлэл дутмаг байсан байна.

Иймээс дээрх зөрчил, дутагдалд дүгнэлт хийж, аймгийн хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд дараахь арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, дүнг энэ оны 7 дугаар сарын 1-ний дотор тус газарт ирүүлнэ үү:

1/ Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, түүнчлэн төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хандив, давхар ажил эрхлэлт, бэлэг, мэдэгдэл, урьдчилсан мэдүүлэгтэй холбоотой бүртгэл хөтлөлтийг бий болгох, улмаар хэвшүүлэх;

2/ давхар ажил эрхлэлттэй холбоотой болон хамаарал бүхий этгээдийн ажил эрхлэлтийн нэгдсэн судалгааг аймгийн хэмжээнд гаргаж, нээлттэй болгох;

3/ төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг явдлыг таслан зогсоох, нийтийн албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

4/ аймаг, сумдын цахим хуудас болон төрийн байгууллага бүрийн мэдээллийн самбараар иргэд шаардлагатай мэдээллээ авах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, түүний тасралтгүй байнгын ажиллагааг хангах, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн болон үйл ажиллагааны талаарх мэдээллийг холбогдох

хууль тогтоомжийн дагуу зохих түвшинд мэдээлэхэд хяналт тавих хяналтын тогтолцоог бий болгох;

5/ орон нутагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, түүний сонгон шалгаруулалттай холбогдох дүрэм, журмыг ил тод, нээлттэй байлгах;

6/ сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангуудын зээлийн тухайн жилийн төсөв, төсөл сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүн, төсөл шалгаруулах хугацааг сурталчлах тогтсон хэлбэрүүдтэй байх, ирсэн төслийн саналууд, шалгарсан төслүүдийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй иргэд олон нийт чөлөөтэй танилцах боломжийг бүрдүүлэх;

7/ мэдүүлэг гаргагч албан тушаалтнуудад мэдүүлгийг үнэн зөв гаргах талаар сургалт зохион байгуулах, тэднийг мэдээллээр хангах, мэдүүлгийг бүртгэх, хүлээн авахдаа хяналт тавих үүргээ хэрэгжүүлэх зэрэг болно.

Хавсралт Ажлын хэсгийн тайлан 8 хуудас.

ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР



Н. ГАНБОЛД